

Гадаадын иргэн, харьяатын газрын
2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
01/1147 дугаар албан бичгийн 02 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 06 дугаар сарын 13

Улаанбаатар хот

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин	Төсөв (сая төг)	Төсвийн гүйцэтгэл (сая төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	4.1.1.11.Визийн зөрчилтэй гадаад иргэдийн тоог бууруулж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах систем болон Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн систем хооронд мэдээлэл харилцан солилцох	2025 - 2028	Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	320.00	-	20	140.00	120.00	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан систем (ISF)-д нэмэлт хөгжүүлэлт хийх” тендер шалгаруулалтыг 04 дүгээр сарын 24-ний өдөр зарлаж, шалгарсан аж ахуйн нэгжтэй 120,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ГИХГ/20250103004/01/06-18 дугаар гэрээг 05 дугаар сарын 21-ний өдөр байгуулан гэрээний хүрээнд “Агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг авах систем”-тэй мэдээлэл солилцохоор хөгжүүлж байна. https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1743570117880	90

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
2		Оршин суух үнэмлэх хэвлэх цэгийг нэмэгдүүлэх	2025 - 2026	Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	500.00	1	4	250.00	0.00	Монгол Улсад оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэнд олгох оршин суух үнэмлэх хэвлэх 1 киоск төхөөрөмжийг Эдийн засаг, хөгжлийн яамны хөрөнгө оруулагчдад зориулсан нэг цэгийн үйлчилгээний төвд байршуулж, 02 дугаар сарын 20-ны өдрөөс үйлчилгээнд нэвтрүүлсэн. Мөн оршин суух үнэмлэх хэвлэх 1 ширхэг төхөөрөмжийг Гадаад харилцааны яаманд хүлээлгэн өгсөн бөгөөд тус яамны Ёслолын газарт дипломат албан, хаагчдын оршин суух үнэмлэхийг хэвлэж байна. Хагас жилийн байдлаар дээрх үйл ажиллагаанд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.	100
3		Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт тоон гарын үсэг олгох	2025 - 2027	Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	350.00	-	40	100.0	0.00	Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт тоон гарын үсэг олгох зорилгоор FS100110_nonGovernmentalOrganizationInfo сервисийг шинээр хөгжүүлэн Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системд 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр гаргасан бөгөөд тоон гарын үсэг олгогч Ньюкомпас скэй ХХК-аас 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн шаардлагад нийцүүлэн гаралтын утгыг шинэчлэн хөгжүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.	90
Үнэлгээ: 93.3 хувь												